

1945 ОНЫ МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛЫН АСУУДАЛ БА ЧАН КАЙШИ МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТЫН ӨМНӨХ ТҮҮХЭН НӨХЦӨЛ

*Табучи Ёоко**

1. Хорьдугаар зууны Монгол түүхэн дэх Монголын тусгаар тогтнолын асуудал

“Гадаад Монгол” буюу БНМАУ бол 1921 оны монгол ардын хувьсгалаас хойш үнэндээ de facto бие даасан байдалтай байв. Гэвч 1945 оны 10-р сарын 20-нд явагдсан Гадаад Монголын ард түмний санал хураалтын дүнг хүлээн аваад, 1946 оны 1-р сарын 5-нд Чан Кайшийн (蔣介石) ДИУ-ын засгийн газраас БНМАУ-ыг хүлээн зөвшөөрсний эцэст БНМАУ сая л хууль ёсоор de jure тусгаар тогтнож, улмаар 1961 онд НҮБ-д гишүүнээр элссэн билээ. Өнгөрсөн XX зууны Монголын тусгаар тогтнолын түүхэнд чухал эргэлтийн үе хоёронтоо тохиосон гэж үзэж болно. Эхний үе нь 1911 болон 1921 онд болсон үндэсний хувьсгал, дараагийн үе нь 1945 он буюу дэлхийн II дайны дараах олон улсын харилцаан дахь өөрчлөлт юм. Ер нь Монголын тусгаар тогтнолын талаар эрдэмтэд олон янзын санал дэвшүүлсэн байдаг ч хорьдугаар зууны эхэн үеийн нөхцөлтэй л уялдуулан судалсан нь олонтаа байдаг. Ялангуяа 1945 оны Монголын тусгаар тогтнолын талаар бодитой судалгаа, шүүмжлэл ховор байна.¹ Энэ нь аргагүй болов уу. Учир нь энэхүү сэдвээр нийтлэгдсэн хэвлэлийн материал ховор, архивуудад хадгалагдан буй холбогдох баримт сэлт ч судалгааны эргэлтэд ороогүй, хаалттай байлаа.

Эл өгүүлэлд зохиогч миний бие Тайваний Улсын түүхийн архивт (国史館 Academia Historica) явуулсан судалгааны үр дүнд шинээр олсон материал бичгийн зарим хэсгээс танилцуулахын зэрэгцээ Монгол Улсын тусгаар тогтнол ба дэлхийн II дайны дараах олон улсын харилцаанд гарсан өөрчлөлт хандлагын уялдаа холбоо, мөн И.Сталин ба Чан Кайши нарын харилцаа уг асуудалд хэрхэн нөлөөлсөн тухай авч үзэхийг зорилоо.

2. Ялтын нууц гэрээ ба Чан Кайши

1945 оны 2-р сарын 11-нд И.Сталин, АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт, Их Британий ерөнхий сайд У.Черчилл нарын Ялтын уулзалтан дээр, фашист Германыг бут цохин, дэлхийн хоёрдугаар дайны дараа дэлхийд энх тайван байдлыг тогтоон бататгах тухайн асуудлыг хэлэлцэн тохиролцжээ. Эл хэлэлцээрийн заалтыг 1946 оны 2-р сар хүртэл нууцлахаар шийдсэн ба түүний доторх заалтын “Алс Дорнодын асуудлаар гурван гүрний байгуулсан хэлэлцээр” гэсэн хэсэгт ЗХУ нь

*Табучи Ёоко - Японы Осакагийн Гадаад хэлний их сургууль, доктор (Ph.D)

холбоотнуудын талд Японы эсрэг дайнд оролцох болзолтойгоор Сталины саналын дагуу “а) Гадаад Монголын (БНМАУ-ын) одоогийн байгаа байдал (status quo)-ыг хэвээр хадгалах, б) Японоос 1904 онд итгэлийг эвдэж халдан довтолсноор зөрчигдсөн Орос орны эрхийг сэргээх (Үүнд Сахалины арал, Далайн боомт, Порт-Артур, Дорнод Хятадын төмөр зам болон Өмнөд Манжуурын төмөр зам дахь ЗХУ-ын онцгой эрхийг зөвшөөрөх), в) Курилын арлуудыг ЗХУ-д шилжүүлэх”-ээр тохиролцжээ. “Гадаад Монголын тухай болон дээр дурдсан боомт, төмөр замын тухай хэлэлцэн тохиролцсон зүйлийг генералиссимус Чан Кайши зөвшөөрсөн байх шаардлагатай” гэж тохиролцсон тул Сталин Японд дайн зарлахаас өмнө Чан Кайшитай энэ талаар гэрээ байгуулах шаардлагатай болжээ. Ийнхүү ДИУ-ыг (Чүншингийн засгийн газрыг) Японы дарлалаас чөлөөлөх зорилгоор ЗХУ-аас зэвсэгт хүчийн тусламж үзүүлэх тухай Сталин Чан Кайшийн хооронд хэлэлцээр хийхээр болсон байна.

Мөн 1945 оны 6-р сарын 15-нд АНУ-аас ДИУ-д суугаа элчин Р. J. Hurley Ялтын хэлэлцээрийн нууц зүйлыг Чан Кайшид албан ёсоор гардуулжээ. Чан Кайши “Энэ хэрэлцээрийн агуулгыг мэдмэгц “бачимдан уурласан” тухайгаа өдрийн тэмдэглэлдээ бичиж, уг хэлэлцээрийг “Эх орны (Хятадын) эрх ашигт харшлах нууц хэлэлцээр” (壳華密約 буюу Хятад улсаа худалдахыг шаардсан нууц гэрээ) гэж нэрлэсэн байдаг.”²

Нөгөө талаар энэ хэлэлцээр Чан Кайшид ашигтай байсан тал ч бий. Юу гэвээс Чан Кайши Сталинтай эвлэрэн гэрээ байгуулах хариу болзол болгож, ЗХУ-аас Хятадын эв хамт намд зэвсгийн тусламж үзүүлэхгүй байх, нийт Хятадын нутаг дэвсгэрт (Гадаад Монголыг эс тооцон) ДИУ-ын эрхийг баталгаажуулах, Шиньжаан, Уйгар дахь үндэсний самуунд мөн зэвсэг нийлүүлэхгүй байх, Японд эзлэгдэж байсан газар нутаг буюу зүүн хойт Хятад болон Өвөр Монголыг Гоминдан Намын захиргаанд оруулан нэгдсэн Хятадад улс буюу ДИУ-ыг байгуулахаар оролдож байлаа.”³

Мөн 6-р сарын 26-нд Чан Кайши “ЗХУ-тай хэлэлцэх 9-н зүйл” тэмдэглэсний дотор 5-р зүйлдээ “Гадаад Монголыг автономит орон болгож Хятадын сюзеренитет (宗主權) эрхтэй дээд зэргийн өөртөө засах засаг (高度自治政府) байгуулж зэвсэгт хүч ба дипломат харилцааг өөрөө тогтоох эрх олгох”-оор шийджээ.⁴ Энэ нь Чан Кайшийн хувьд Сталинтай эвлэрэх гол нөхцөл байсан юм. Чан Кайшийн хэлж буй “Хятадын сюзеренитет эрх (宗主權)” гэдэг нь 1915 оны Хиагтын Гэрээнд тогтоосон “Хятадын сюзеренитет эрх (宗主權)”-ээр ялгагдах бөгөөд “зэвсэгт хүч ба дипломат харилцааг өөрөө тогтоох эрх”-ийг олгосноос Хятадын талд бодит эрх ашиггүй нэр төдий зүйл байв. Мөн өдөрт Чан Кайши ЗХУ-аас ДИУ-д суугаа элчин А.А.Петровт “Гадаад Монголын

асуудал нь Төвдөд ч хамаарах асуудал болох тул хэлэлцэхгүй байвал туйлын сайн байна” хэмээн дамжуулж байсан юм.⁵

3. Москва дахь ЗХУ ба ДИУ-ын хэлэлцээрийн эхний үе шат

Чан Кайши ГЯЯ-ны сайд бөгөөд Засаг захиргааны зөвлөлийн дарга Сүн Зивэнийг (宋子文) ДИУ-ын төлөөлөгчөөр томилон, 1945 оны 6-р сарын 30-наас ДИУ ба ЗХУ-ын хооронд найрамдалт харилцааны гэрээ байгуулахаар Москвад илгээсэн байна. Сталин Сүн Зивэн нар зургаан удаа ярилцсанаас хамгийн ширүүн маргалдсан сэдэв нь Гадаад Монголын асуудал буюу “Гадаад Монголын одоогийн байгаа байдал (status quo)” гэдгийг хэрхэн ойлгох вэ гэдэг асуудал байжээ.

7-р сарын 2-нд Сталин ДИУ-д БНМАУ-ын бүрэн эрхт тусгаар тогтнолыг зөвшөөрөхийг хатуу шаардсаны дагуу мөн сарын 3-нд БНМАУ-ын ерөнхий сайд маршал Х.Чойбалсан тэргүүтэй төлөөлөгчдийг Дуглас онгоцоор анх удаа Москвад урьж авчран, Гадаад хэргийн ардын комиссар В.М.Молотов тэргүүтэй албаны хүмүүс дээд зэргийн хүндэтгэлтэйгээр угтан авч байгааг Сүн Зивэн тэргүүтэй ДИУ-ын төлөөлөгчдөд зориуд харуулжээ.⁶ Энэ тухай АНУ-аас ЗХУ-д суугаа элчин W.A.Harriman “Энэ удаагийн ЗХУ-аас үзүүлсэн албан ёсны хүндэтгэл бол E.Stettinius (тухай үеийн АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга), Benesh (Чехийн ерөнхийлөгч) болон Сүн Зивэн нартай адил буюу дээд хэмжээгээр хүлээн авч байна” хэмээн АНУ-ын төрийн нарийн бичгийн газарт цахилгаанаар мэдэгдэж байжээ.⁷

Сүн Зивэнээс 7-р сарын 2-ны зөвлөглөөний тухай цахилгаан мэдээ хүлээн авсан Чан Кайши дэлхийн хоёрдугаар дайны дараа нэгдсэн ДИУ-ыг байгуулахын зэрэгцээ ЗХУ-тай найрамдалт харилцааны гэрээ байгуулахын тулд зохих хэмжээний буулт хийхээс өөр аргагүй болжээ. Тэрхүү буулт нь Гадаад Монгол дахь Хятадын сюзеренитет эрхийг (宗主權) хүчингүй болгох гэсэн Чан Кайшийн хувьд “асар том золиос” байлаа.⁸ Мөн сарын 6-нд Сүн Зивэнд явуулсан цахилгаандаа “Дайны дараа Гадаад Монголд бүх нийтийн санал хураалтаар тусгаар тогтнолоо батлах юм болбол ДИУ-ын засгийн газрын хурлаар албан ёсоор хэлэлцсэний дараа тусгаар тогтнолыг нь хүлээн зөвшөөрнө” гэж мэдэгджээ.⁹ Маргааш нь буюу 7-нд “Гадаад Монголын хил хязгаарыг тогтоохдоо ДИУ-д хэрэглэгдэж буй газрын зургийг үндэс болгох ба ЗХУ-д хэрэглэгдэж буй газрын зурагт Гадаад Монголын нутаг дэвсгэрт Алтайн нуруу багтаж байгаа”-г анхааруулж байжээ.¹⁰ Гэхдээ Сүн Зивэн ДИУ-ын газрын зургийг авч очоогүй учраас энэ удаагийн хэлэлцээрээр хил хязгаарын асуудал ярилцахаа түр хойшлуулжээ. Ингээд хоёр этгээд тодорхой үр дүнд хүрэлгүй Сталин Подстамын гурван гүрний уулзалтанд оролцохоор Герман явахаар болж, Сүн Зивэн мөн сарын

12-нд Чүнчинд булжээ.

4. Москва дахь ЗХУ ба ДИУ-ын хэлэлцээрийн дараагийн үе шат

ЗХУ ба ДИУ-ын хэлэлцээр Москвад 8-р сарын 7-ноос 14-н хүртэл дахин үргэлжилж, нийт дөрвөн удаа уулзжээ. ДИУ-ын талаас ГЯЯ-ны сайдаар шинээр томилогдсан Ван Шизэ (王世杰) ба өмнөх хэлэлцээрт ДИУ-ыг төлөөлж байсан Засаг захиргааны зөвлөлийн дарга Сүн Зивэн нар оролцсон. Мөн сарын 6-нд АНУ-ын цэрэг Японы Хирошимад цөмийн бөмбөг хаяж, Япон удахгүй ялагдах нь тодорхой болмогц Сталин Японы эсрэг дайнд оролцохыг яаравчилжээ.

Мөн 8-р сарын 10-нд Ван Шизэ Сталинтай хийсэн хэлэлцээр дээр ДИУ-аас авчирсан газрын зургийг үзүүлж Гадаад Монголын хил хязгаарын асуудлыг тавьсан боловч, Сталин эл асуудлыг гэрээнд оруулахаас татгалзсан. Улмаар “Хэрвээ ДИУ-аас Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй бол Дотоод Монголын ах дүү нар Нармай Монгол Улс байгуулахаар Гадаад Монголтой тохиролцож магадгүй шүү” гэж Ван Шизэ тэргүүтэй ДИУ-ын төлөөлөгчдөд анхааруулж байжээ.¹¹

Ван Шизэ Чан Кайшид мэдэгдсэнээр бол Сталин хил хязгаарын асуудлыг гэрээнд оруулахаас татгалзсаны шалтгаан нь “ЗХУ-ын талын газрын зурагт Шиньжаан болон Тагна Урианхайн нутаг дэвсгэр орсон тул хил хязгаарын талаар ДИУ-тай тохиролцох нь бэрхшээлтэй гэж үзэж байгаа бололтой” гэжээ.¹²

Мөн 8-р сарын 12-нд Чан Кайши нь Ван Шизэд явуулсан цахилгаандаа “Гадаад Монгол тусгаар тогтнохыг эрмэлзэж байгаагаас хойш, хил хязгаарыг нь тогтоох тулгуур газрын зураг хэрэгтэй байна” гэж мэдэгджээ.¹³ Ийнхүү Сталин ба Чан Кайшийн хооронд хавчигдсан Ван Шизэ “ДИУ нь Гадаад Монголын тусгаар тогтнолыг 1919 оноос өмнөх нутаг байдлаар бус одоогийн байгаа хилээр хүлээн зөвшөөрнө гэдгийг тодорхойлохын тулд” гэрээн дотор “одоогийн байгаа хилээр хүлээн зөвшөөрнө” хэмээх үг оруулах саналыг дэвшүүлжээ.¹⁴ Үүнийг Сталин хүлээн зөвшөөрснөөр хоёр этгээд харилцан тохиролцоонд хүрчээ.

Эцэст нь 1945 оны 8-р сарын 14-нд найрамдалт харилцааны гэрээ бичигт ДИУ-ын ГЯЯ-ны сайд Ван Шизэ, ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар В.М.Молотов нар Москвад гарын үсэг зурав. Гадаад Монголын талаар “Гадаад Монголын ард түмэн тусгаар тогтнох хүсэл эрмэлзлээ байнга илэрхийлсээр байгаа тул Япон улс дайнд ялагдсаны дараа Гадаад Монголын иргэдийн дунд явуулах санал асуулга энэхүү хүсэл эрмэлзлийг нь нотлон харуулбал ДИУ-ын засаг Гадаад Монголын тусгаар тогтнолыг одоогийн байгаа хилээр нь хүлээн зөвшөөрнө” гэдгийг ДИУ-аас харилцан солилцсон ноот бичигт дурджээ.

Ийнхүү ДИУ ба ЗХУ-ын хооронд БНМАУ хууль ёсоор бүрэн эрхт бие даасан улс болох түүхэн ач холбогдолтой гэрээ байгуулагджээ. Харин ДИУ-ын засгийн газар буюу Чан Кайшийн хувьд Гадаад Монголын хил хязгаарын асуудалд бүрэн эвлэрсэн хэрэг бус “одоогийн байгаа хил” гэдгийг ЗХУ буюу Гадаад Монголын талтай тодорхойлтол түр хойшуулж байсан хэрэг юм.

5. Чойбалсан Японы эсрэг дайн зарласан нь

1945 оны 8-р сарын 9-нд ЗХУ 1941 онд байгуулсан төвийг сахих тухай гэрээг зөрчиж Японд дайн зарлав. Маргааш нь буюу мөн сарын 10-нд БНМАУ-ын Бага хурал ба Засгийн газар Японы эсрэг дайн зарлан тунхаглав. Мөн өдрийн “Үнэн” сонинд нийтлүүлсэн эл тунхагт:

“...Халх, дөрвөд, торгууд, ойрад, буриад, барга, өвөр монгол, цахар, ордос, харчин, дарьганга, алшаа, дээд монгол овогтон, түүнчлэн БНМАУ-ын нутаг, жич Японд түр эзлэгдсэн зэрэг газар оршин буй казах, урианхайн ард, гадаадын түрэмгийлэн эзлэгч этгээд Японы боолчлон дарлагчдын зүгээс монгол овогтны амсаж буй гашуун зовлон дарлалыг үүрд устгаж, Монголын ард түмэн хэл бичиг, үндэсний соёл боловсролоо эрхлэн улмаар боловсруулж өөрийн үндэсний хэв заншил, шашин суртахууныг сахиж өөрийн улсын бүрэн эрхт тусгаар тогтнох байдлыг улмаар бататган боловсруулж, аж амьдралыгаа эрх чөлөө, тусгаар тогтнолын ёс зүйд нийтүүлэн зохиохын тул, цөм энэхүү ариун дайнд нэгэн зэргээр хөндлөн босогцоох биз хэмээн нотод итгэж баймуй” гэжээ.¹⁵

Монгол Ардын Хувьсгалт цэрэг нь Зөвлөлтийн армийн Өвөр Байгалийн фронтын бүрэлдэхүүнд багтаж, Зөвлөлт-Монголын цэргийн морьт механикжуулсан группыг бүрэлдүүлэн, мөн 8-р сарын 23-н хүртэл Жэхэ, Чуулалт Хаалга орчин хүртэл давшжээ.

Ийнхүү Чойбалсан панмонголизм үзэлтэй тунхаг гаргасан нь сонирхол татна. Юу гэвээс тухайн үед ДИУ ба ЗХУ-ын найрамдалт харилцаа гэрээ албан ёсоор зарлаагүй байсан боловч Чойбалсан тус гэрээний агуулга, тухайлбал ДИУ-аас зөвхөн Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх тухай 7-р сарын эхээр Сталинаар дамжуулж мэдэж байсан юм.¹⁶

Японы засгийн газар 8-р сарын 14-нд бууж өгөхийг зөвшөөрч байгаагаа мэдэгдсэн яг тэр өдөр Москвад ДИУ ба ЗХУ-ын найрамдалт харилцааны гэрээ байгуулагдаж, мөн сарын 27-нд Чүнцинг гардаг байсан Гоминдан Намын “Төвийн Сонин” (中央日報) -д бүрэн эхээр нийтлэгджээ. БНМАУ-ын талд “Үнэн” сонины мөн сарын 29-ны өдрийн дугаарт мөн нийтлэгдсэн билээ. Үүнээс хойш “Үнэн” сонинд панмонголизмын үзэлтэй мэдээ мэдээлэл огт гарахаа больжээ.

6. Чан Кайши Гадаад Монголын санал хураалтыг ажиглах
төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг томилсон нь

9-р сарын 25-нд ДИУ-ын засгийн газар Москвад суугаа элчнээрээ дамжуулан хүлээн авсан Чойбалсангийн ард түмний санал хураалтын тухай илэрхийлэл бичигт:

“...Монголын ард түмэн хувьсгалт ололтоо хамгаалж капиталист Япон улс Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолд удаа дараалан өнгөлзөхөөр санаархаж байсныг зэвсгийн хүчээр эсэргүүцэн тэмцэж байсны зэрэгцээгээр энэхүү хамгийн сүүлчийн түрэмгийлэгчийг бут ниргэхэд оролцож байсан энэ нөхцөл байдлын дор Монгол ард түмнээс тусгаар тогтнох хүсэл эрмэлзэлтэй эсэхийг асуух нь илүүц юм. ...Энэхүү тусгаар тогтнолыг монголын охид хөвгүүдийн ариун цусаар сольж авсан зүйл, иймийн тулд БНМАУ 1945 оны 10-р сарын 10-ны өдрөөс 20-ны өдөр хүртэлх хугацаанд бүх нийтийн санал хураалтын ажлыг явуулахаар тогтсон юм. ...БНМАУ-ын засгийн газар ДИУ-ын засгийн газрыг төлөөлөгчөө илгээж бүх нийтийн санал хураалтанд оролцуулахыг зөвшөөрч байгаа болно. ...1945-ны 10-р сарын 10-ны өдөр төлөөлөгчидөө Чүнцин хотноо илгээж санал хураалтын дүнг танилцуулах боломжгүй болсон тул ДИУ-ын засгийн газар хүсвэл БНМАУ-ын төлөөлөгчөөс санал хураалтын дүнг шууд авч болно. БНМАУ энэ оны 11-р сарын эхээр төлөөлөгчөө Чүнцинд илгээж санал хураалтын дүнг танилцуулах болно” гэжээ.¹⁷

Ийнхүү 10-р сарын 10-ны ДИУ-ын улсын баярын өдөр (1911 оны мөн өдөр цагаачин гахай жилийн хувьсгал эхэлжээ) Монголын төлөөлөгчдийг Чүнцинд ирүүлэх ДИУ-ын санаархал бүтсэнгүй.

Чан Кайши нь санал хураалтыг ажиглах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг томилохын зэрэгцээ Улсыг Батлан Хамгаалах Дээд Зөвлөлд (УБХДЗ-д) БНМАУ-ын засгийн газартай хэрхэн хэлэлцээр явуулах тухай саналаа оруулан хэлэлцүүлжээ. Үүнд:

Нэгдүгээрт төлөөлөгчид Гадаад Монголд байх хугацаанд санал хураалтын үйл ажиллагаанд оролцохгүй, зөвхөн Хятад хэлээр ярих, “Гадаад Монгол” хэмээх нэр томъёо хэрэглэх, “11-р сарын эхээр Гадаад Монголын төлөөлөгчдийг Чүнцинд ирүүлэх хүсэлтэй” байгааг уламжлахыг үүрэг болгожээ.¹⁸ Энэ нь 11-р сарын 12 буюу ДИУ-ын анхны ерөнхийлөгч Сун Ятсэний төрсөн өдрийн баяр ёслолд Монголын төлөөлөгчдийг урих нь Хятадын хувьд түүхэн ач холбогдолтой хэрэг мөн хэмээн үзэж байсантай холбоотой.

Хоёрдугаарт төлөөлөгчдийн тэргүүнээр Дотоод Явдлын Яамны орлогч сайд Лэй Фажанг (雷法章) томилсон байна.¹⁹

Гуравдугаарт Чан Кайши “Хэрвээ хил давж ДИУ-ын нутаг дэвсгэрт санал хураалт явуулбал хил хязгаарын асуудлаар

эсэргүүцлийн меморандум (備忘録) гаргах” хэмээн шаардаж байсан.²⁰ Дөрөвдүгээрт Гадаад Монголын тусгаар тогтнолыг хэзээ хүлээн зөвшөөрөх вэ гэдэг асуудлаар хамгийн ширүүн маргалджээ. Чан Кайшийн хувьд хил хязгаарын асуудлаа шийдвэрлэсний дараа сая Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх санаатай байсан. Харин 10-р сарын 1-ний УБХДЗ, Гоминдан Намын Төвийн Гүйцэтгэх Хорооны (ГНТГХ) хамтарсан хурал дээр “Гадаад Монголын төлөөлөгчид Чүнцинд хүлээн авахаас өмнө тэдний тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх нь зохистой. Энэ нь тэднийг ямар түвшинд хүлээн авах гэх мэт асуудалтай холбогдно” хэмээн санал дэвшүүлж байсан.²¹ Чан Кайши үүний хариуд “Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхийг яаравчилж болохгүй” хэмээн мэдэгджээ.²² Харин мөн сарын 15-ны ГНТГХ-ны хурал дээр уг асуудлаар дахин маргалдан УБХДЗ-ын нарийн бичгийн дарга Ван Чухуй (王寵惠) Чан Кайшид “ДИУ ба ЗХУ-ын хооронд байгуулсан гэрээнд манай засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх нөхцөл болбоос зөвхөн санал хураалтын дүнгээ гаргахад оршино” хэмээжээ.²³

Чан Кайшийн хувьд БНМАУ-ын хүслээр хил хязгаар тогтоохоос болгоомжилж байсан бололтой. Гэхдээ тухайн үед Шиньжаан, Зүүн Хойт Хятад улс төрийн байдал бөгөөд Гоминдан нам ба Хятадын эв хамт намын хоорондын зөрчилдөөний улмаас байдлыг улам хурцатгахгүйн тулд ДИУ-ын хувьд аль болохоор хурдан ЗХУ-аар гэрээ биелүүлэх нь хамгийн чухал хэрэг байжээ.

Эцэст нь Чан Кайши хил хязгаарын асуудлаар меморандум (備忘録) гаргахад больсон мэт. Юу гэвээс 10-р сарын 16-нд Ван Шизэгээс Лэй Фажанд “Гадаад Монголд байхдаа хил хязгаарын асуудлаар үг хэлэхгүй байх ба энэ асуудалтай холбогдох баримт бичиг хүлээн авах, гарын үсэг зурахыг хориглоно. Меморандум (備忘録) гаргах хэрэггүй” хэмээн мэдэгджээ.²⁴

7. Төгсгөл

Гадаад Монголын тусгаар тогтнолын талаарх бүх нийтийн санал хураалтыг ажиглахаар томилсон төлөөлөгчдийн тэргүүлэгч Лэй Фажан, 10-р сарын 8-нд 11 тушаалтныг төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд томилж, улмаар 2 ажилтан ба 1 сонин сурвалжлагч нэмэн бүгд 15 төлөөлөгчийн хамт Бээжингээс Улаабаатарт онгоцоор нисэх төлөвлөгөөтэй байжээ. Гэвч ЗХУ-аас бэлтгэсэн нисэх онгоцд 15 хүн багтахгүй гээд 3 хүн Бээжинд аргагүй үлдэн, 12 төлөөлөгч ниссэн байна. Төлөөлөгчид мөн сарын 18-нд нисэх онгоцоор Улаанбаатарт хүрэлцэн ирж Нүхтэд байрлан санал хураалтын явцыг ажигласны дараа Чүнцинд буцахаар 24-нд Бээжинд нисжээ. Лэй Фажан Чойбалсанд удаа дараа “11-р сарын

12 буюу ДИУ-ын анхны ерөнхийлөгч Сун Ятсений төрсөн өдрийн баяр ёслолд Монголын төлөөлөгчдийг ирүүлэх”-ийг уламжилсан боловч тэр Чан Кайшийн хүсэл эрмэлзэл бас л бүтсэнгүйгээр Гадаад Монголын тусгаар тогтнолыг аргагүй хүлээн зөвшөөрчээ.²⁵

Тухайн үеийн Хятадын дотоод гадаадын улс төрийн байдлаас үзвэл 1945 оны 8-р сарын 28-наас 10-р сарын 10-нд Чүнцинг Гоминдан нам ба Хятадын эв хамт намын удирдлагын хэмжээнд хэлэлцээ хийж, удаан маргалдсаны эцэст “Энх тайвнаар улсаа байгуулах үндсэн чиглэл”-ийг баримтлан “энх тайван, ардчилал, бүлгэмдэл, нэгдлийг үндэс болгож ...дотоодын дайнаас эрс шийдэмгийн зайлсхийж, тусгаар тогтносон, эрх чөлөөтэй баян хүчирхэг шинэ хятад улсыг байгуулах”, Улс Төрийн Зөвлөлдөх Хурал (政治協商會議) буюу Чхэн цжин сиэшань хүй и) хуралдуулах, түүнд улс төрийн олон нам бүлгийг адил тэгш эрхтэйгээр оролцуулахаар тохиролцсон. Гэвч цэрэг, засаг захиргаа зэрэг үндсэн асуудлаар тохиролцоонд хүрч чадаагүй байсан бөгөөд Гоминдан нам ба Хятадын эв хамт намын хоорондын зөрчилдөөний улмаас байдал улам хурцдаж дотоодын иргэний дайн дэгдэх аюултай нөхцөл болж байжээ. Бас нөгөө талд Гоминдан нам буюу Чан Кайшийн хувьд ЗХУ-ын цэргээр чөлөөлөгдсөн зүүн хойт Хятад нутгийг нэн даруй захиргаандаа оруулахыг оролдсон боловч энэ нь ЗХУ-аас шалтгаалж хялбархан бүтэх асуудал биш гэдэг нь улам бүр тодорхой болсон юм.

Дэлхийн хоёрдугаар дайны дараах олон улсын харилцааны өөрчлөлтийн зааг үед ЗХУ ба ДИУ-ын хоорондын харилцааг батлан тогтоож ДИУ ба ЗХУ-ын хооронд байгуулсан найрамдалт харилцааны гэрээний заалтыг биелүүлэх нь ДИУ-ын ирээдүйд хамаарах амин чухал асуудал мөн байсан тул Чан Кайшийн хувьд Гадаад Монголын тусгаар тогтнолын талаар шийдвэртэй арга хэмжээ авах бололцоогүй байсан гэж үзэж болно.

Ийнхүү олон улсын хүч харилцааны өөрчлөгдөх зааг үед БНМАУ олон улсын хэмжээнд бүрэн эрхт бие даасан улсын статусаа сая хүлээн зөвшөөрүүлэх нөхцөл бүрдэж хорьдугаар зууны Монгол тусгаар тогтнолын асуудал шийдвэрлэх шинэ үе шат эхэлсэн билээ.

Ишлэл зүүлт

1. Энэ асуудлаар чухалд тооцогддог бүтээл нь Л.Жамсран “Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт” Улаанбаатар 1997, Christopher P. Atwood “Sino-Soviet Diplomacy and the Second Partition of Mongolia, 1945-1946” ed. Stephen Kotkin and Bruce A. Elleman “Mongolia in the twentieth century” M.E. Sharpe. New York 1999 pp. 137-161, Кашима Акио “сүтүмунгуру ну чүгөкү ридацү о мэгүрү чүсу канкэй” “чүсу гайкуши кэнкиү 1937-1946” (香島明雄「外モンゴルの中国離脱をめぐる中ソ関係」『中ソ外交史研究 1937-1946』) Япон 1990 он 172-209-р тал.

2. “Зун тун чан гүн да ши чан биэн чү гау” (秦孝儀総編『総統蔣公大事長編初稿』 Чан Кайшийн өдрийн тэмдэглэл) 5-р доод боть Тайвань 1978 он 726-р тал.

3. Мөн 732-р тал

4. Мөн 735-р тал

5. Мөн 738-р тал

6. “Улаан Од” сонин 1945 оны 7-р сарын 7-ны өдрийн дугаар, Л.Бат-Очир “Чойбалсан” Улаанбаатар 1996 он 173-175-р тал, П.Шагдарсүрэн “Миний мэдэх маршал Х.Чойбалсан” Улаанбаатар 2002 он 117-118-р тал.

7. U.S Department of State publication “Foreign Relation of the United States 1945 (7)” U.S.G.P.O Washington D.C 1969, p.917

8. “Зун тун чан гүн да ши чан биэн чү гау” 747-р тал.

9. “Зун тун чан гүн да ши чан биэн чү гау” 747-р тал.

10. “Зун тун чан гүн да ши чан биэн чү гау” 751-752-р тал.

11. “Foreign Relation of the United States 1945 (7)” pp.967-969.

12. “Зун тун чан гүн да ши чан биэн чү гау” 793-794-р тал.

13. “Зун тун чан гүн да ши чан биэн чү гау” 789-790-р тал.

14. “Зун тун чан гүн да ши чан биэн чү гау” 793-794-р тал.

15. “Үнэн” сонин 1945 оны 8-р сарын 10-ны өдрийн дугаар.

16. Л.Бат-Очир “Чойбалсан” 173-176-р тал.

17. Academia Historica, Го мин жэн фү дан ан “мэн чи жэн чин” 0590.02-2344.01-01, 国史館, 国民政府档案『蒙旗政情』) 1945 он 9-р сарын 19-ны өдөр, Москвад суугаа ДИУ-ын элчин Фү Бинчангаас ДИУ-ын ГЯЯ-д явуулсан бичиг. /Чжан Дажүн “вай мэн шэн дай ши” (張大軍『外蒙現代史』) Тайбэй 1983 он 4-р боть 1525-1526-р талд буй хэсгийг монголчилсон Г.Гунгаа “Хятад, Оросын харилцааны түүхэн дэх Монгол улс” Улаанбаатар 1995 он 83-84-р талаас авав./

18. Academia Historica, Го мин жэн фү дан ан “мэн чи жэн чин” 1945 он 10-р сарын 1-ний өдөр, Улсыг Батлан Хамгаалах Дээд Зөвлөлд (УБХДЗ), Гоминдан Намын Төвийн Гүйцэтгэх Хорооны (ГНТГХ)

хамтарсан хурал.

19. Academia Historica, Го мин жэн фү дан ан “мэн чи жэн чин” 1945 он 9-р сарын 28-ний өдөр, УБХДЗ-ын нарийн бичгийн дарга Ван Чухуйгаас Чан Кайшид явуулсан бичиг. Мөн 1945 он 10-р сарын 8-ны өдөр, Лэй Фажангаас Чан Кайшид явуулсан бичиг.

20. Academia Historica, Го мин жэн фү дан ан “мэн чи жэн чин” 1945 он 10-р сарын 1-ний өдөр, УБХДЗ, ГНТГХ-ны хамтарсан хурал. Мөн “вай мэн гүн мин туу фиао юү бай мэн дү ли” (外蒙公民投票與外蒙獨立) 0591.30-4408.01-01, 1945 он 10-р сарын 9-ний өдөр, Чан Кайшигаас Ван Чухуйд явуулсан бичиг.

21. Academia Historica, Го мин жэн фү дан ан “мэн чи жэн чин” 1945 он 10-р сарын 1-ний өдөр, УБХДЗ, ГНТГХ-ны хамтарсан хурал.

22. Academia Historica, Го мин жэн фү дан ан “мэн чи жэн чин” 1945 он 10-р сарын 3-ны өдөр, Чан Кайшигаас ДИУ-ын нарийн бичгийн газарт явуулсан бичиг.

23. Academia Historica, Го мин жэн фү дан ан “мэн чи жэн чин” 1945 он 10-р сарын 18-ны өдөр, Ван Чухуйгаас Чан Кайшид явуулсан бичиг.

24. Academia Historica, Го мин жэн фү дан ан “мэн чи жэн чин” 1945 он 10-р сарын 16-ны өдөр, Ван Шизэгээс Лэй Фажанд явуулсан бичиг. Мөн сарын 18-ны өдөр, Ван Шизэгээс Чан Кайшид явуулсан бичиг.

25. Табүчи Ёоко “1945 нэн мунгурүнү дукүрицү мундай у мэгүрү мунгурү жинмин киувакүкү то чүкаминкүкү (1945 он Монголын тусгаар тогтнолын талаарх БНМАУ ба ДИУ)” “Гэндай чиугүкү кэнкиү” 田淵陽子 “1945年「モンゴル独立問題」をめぐるモンゴル人民共和国と中華民国” 『現代中国研究』 Япон 2002 он No.11, 74-97-р тал.